



The Asia Foundation



“БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ АВЛИГА, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗӨВЛӨМЖ

Боловсролын салбарын төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан “Боловсролын салбар дахь авлига, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, ерөнхий 4 сэдвийн хүрээнд дараах илтгэлүүдийг хэлэлцсэн:

Нэг. **“Боловсролын салбарын авлигын нөхцөл байдал”** сэдвийн хүрээнд:

1. “Өсвөр үеийнхний дуу хоолой-2 “Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчил” судалгааны үр дүн” /Илтгэгч Э.Цолмон, Хүүхдийг Ивээх Сангийн хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрийн зохицуулагч/
2. “Боловсролын салбар дахь авлигын гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл” /Илтгэгч Ц.Шинэбаяр, Авлигатай тэмцэх газрын Судалгаа, шинжилгээний албаны дарга, ахлах комиссар/
3. “Боловсролын систем дахь авлига, анхаарах асуудал” /Илтгэгч Т.Намнан, ШУТИС-ийн Олон улсын дээд боловсрол судлалын төвийн доктор, дэд профессор/
4. “Боловсролын салбарын ил тод байдал, ёс зүй, авлигын асуудал” судалгаа” /Илтгэгч А.Баянмөнх, “Азийн сан”-гийн Засаглалын хөтөлбөрийн менежер/

Хоёр. **“Боловсролын салбарын ил тод байдал”** сэдвийн хүрээнд:

1. “Боловсролын салбарт хийгдсэн зарим аудит” /Илтгэгч А.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудиторын зөвлөх, Доктор (Ph.D), дэд профессор/
2. “Боловсролын салбар дахь хөрөнгө оруулалтын бодлого, хэрэгжилт” / Илтгэгч Ж.Сайнзаяа, “Үнэн хатамж” ТББ-ын гүйцэтгэх захирал/
3. “Нийслэлийн боловсролын байгууллагуудад хийсэн сүүлийн 3 жилийн хяналт шалгалт, түүний үр дүн” /Илтгэгч Д.Цэнд-Аюуш, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтсийн дарга/

Гурав. **“Боловсролын салбар дахь авлигаас урьдчилан сэргийлэх нь”** сэдвийн хүрээнд:

1. “Боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарах зарим асуудал” /Илтгэгч Д.Тунгалаг, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн Ерөнхий зохицуулагч/
2. “Боловсролын салбар дахь авлигын шалтгаан нөхцөлийг арилгахад иргэний нийгэм, ТББ-ын оролцоо” /Илтгэгч Б.Батжаргал, “Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг” ТББ-н гүйцэтгэх захирал/
3. “Боловсролын салбар дахь авлигаас урьдчилан сэргийлэх арга зам” /Илтгэгч С.Ганчимэг, Нийслэлийн Боловсролын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга/

Дөрөв. **“Боловсролын салбар дахь авлигаас урьдчилан сэргийлэхэд мэдээллийн технологийг ашиглах нь”** сэдвийн хүрээнд:

1. “Боловсролын салбарын мэдээллийн систем ба авлигаас урьдчилан сэргийлэх асуудал” /Илтгэгч Э.Цэрэнцоодол, Боловсролын салбарын мэдээллийн системийн хөгжүүлэлтийн багийн ахлагч/
2. “Блокчэйн технологийг ашиглан боловсролын салбар дахь авлигаас урьдчилан сэргийлэх асуудал, олон улсын туршлага” /Илтгэгч Г.Лхамсүрэн, “Ай Си Ти Групп” ХХК-ийн захирал/
3. “Боловсролын салбарын хөгжлийн бодлого төлөвлөлтийн уламжлал, өнөөгийн нөхцөл байдал болон цаашдын чиг хандлага” /Илтгэгч Б.Баярсайхан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга/

Хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн дараах “Зөвлөмж”-ийг гаргалаа.



ЗӨВЛӨМЖ

1

Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, боловсролын тогтолцооны үзэл баримтлалыг олон улсын туршлага, хандлага, МОНГОЛ ҮНДЭСТЭН-ий онцлогийг харьцуулан судалсны үндсэн дээр боловсруулж, боловсролын салбарын бүх шатанд нэг мөр хэрэгжүүлэхэд анхаарах.

Баримт: *Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө хэрэгжиж дууссан. Боловсролын салбар одоо төлөвлөгөөгүй, үзэл баримтлалгүй явж байна.*

2

Монгол Улс дахь боловсролын эдийн засгийн чиглэлээр суурь судалгаа хийж, түүний үр дүнд төрийн бодлого боловсруулах, боловсролын эдийн засгийн орчинг олон нийтэд ил тод байлгах, тэдний оролцоог хангах.

Баримт: *2014 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуулийн судлаачдын хийсэн “Боловсролын салбарын санхүүжилтийн тойм судалгаа”-гаар Боловсролын яамны боловсролын салбарын санхүүжилтийн бодлого нь тэгш бус байдлыг гүнзгийрүүлж, гааруулсан бодлого явж байна гэж дүгнэсэн. Сүүлийн жилүүдэд нэгдүгээрт, улсын төсвөөс олон улсын хөтөлбөртэй төрийн өмчийн 3 сургууль, (кембрижийн) мөн лаборатори 31 сургуулийг илүү хэмжээгээр санхүүжүүлсэн, хоёрдугаарт, улсын төсвөөс хувийн сургуулиудын хувьсах зардлыг санхүүжүүлсэн нь боловсролын санхүүжилтийн бодлого тэгш бус байдлыг аажмаар нэмэгдүүлж байж болзошгүй гэсэн дүгнэлт хийсэн байна.*

Боловсролын салбар дахь төрийн өмчийн нэгдсэн тооллого, дахин үнэлгээг 2009 оноос хойш хийгээгүй. Тухайлбал, “Буянт-Ухаа” спорт цогцолборын үндсэн хөрөнгийг анх 24 тэрбумаар үнэлжээ. Гэвч дансны үнэлгээг хувийн байгууллагаар хийлгэж 3 тэрбум болгосон байна.

3

Оюутан, сурагчдад шударга ёсны үзэл санаа төлөвшүүлэх, авлигын эсрэг боловсрол олгох хичээлийн агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, багшийн мэргэжил олгох сургалтын хөтөлбөр, стандартад тусгаж, гэр бүл, эцэг эхийн оролцоотойгоор хэрэгжүүлэх арга хэмжээг яаралтай авах.

Баримт: *Хүүхдийг ивээх сангийн “Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчил” судалгаагаар Үндэсний хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчил их байна, энэ асуудал хэзээ алга болох юм бэ? гэж асуухад иргэд “ирээдүйн хүүхдүүд үүнийг өөрчилнө” гэж хариулсан байна. Судалгаанд оролцсон*



The Asia Foundation



Боловсролын
Хамтын Ажиллагааны
Нийгэмлэг



хүүхдүүдээс авлигын талаар асуумж асуухад “Дүүг нь цэцэрлэгт өгөхийн тулд аав, ээж нь авлига өгч байсан” хэмээн хэлсэн.

4

Боловсролын салбарын “Зөвлөлдөх механизм” бий болгож, яам, хандивлагчид, багш нарын үйлдвэрчний эвлэл, хувийн хэвшлийн боловсролын байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг талуудын оролцоог, хангах, чадваржуулах.

5

Боловсролын байгууллагын үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэмжээг үйлчилгээний стандарт, чанар, хүрэх үр дүнтэй уялдуулан тогтоох, санхүүжилтэд улсын төсвийн жилийн орлогын 20-иос доошгүй хувийг зарцуулах тухай зохицуулалтыг хуульд тусгуулах арга хэмжээ авах.

Баримт:

Боловсролын асуудал эрхэлсэн сайдын багц дахь боловсролын салбарын төсөв улсын төсвийн зардалд эзэлж байгаа хувь 2013 онд 15%, 2014 онд 17%, 2015 онд 14%, 2016 онд 13%, 2017 онд 15% байна. “Бүх нийт боловсролын төлөө!” ТББ-ын судалгаагаар боловсролын салбарт хуваарилж байгаа төсөв бага байгаа нь авлига гарах шалтгаан болж байна. Өөрөөр хэлбэл, сургууль засах, анги танхим тохижуулах зардал хүрэлцээгүй учраас хууль бус хандив, хураамж авч байна. Тухайлбал, 2018 онд 75 цэцэрлэг анги танхимын тохижилт үйлчилгээнд зориулж, эцэг эхийн хандив тусламжаар нэг хүүхдээс 5.0-100.0 мянган төгрөг хураан авсан. Хан-Уул дүүргийн 218 дугаар цэцэрлэг 15 хүүхдээс тус бүр 92.0 мянган төгрөг буюу нийт 1379.9 мянган төгрөг, 50 хүүхдээс 22.0 мянган төгрөг буюу нийт 1.100.0 мянган төгрөгийг албадлагын шинжтэйгээр, хавтгайруулан хурааж агаар шүүгч, хөгжим зэргийг авсан.

6

Яаманд гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хөрөнгийг зарцуулалт, Боловсролын зээлийн сан, Шинжлэх ухаан, технологийн сан, Спортыг дэмжих сан зэрэг сангуудын үйл ажиллагаа, шийдвэр, тайланг ил тод болгох, эрх зүйн орчинг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх.

Баримт:

Аудитын байгууллагаас боловсролын салбарт 534 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлсэн. Үүнээс 221 тэрбум төгрөгийн авлага, өглөгтэй холбоотой зөрчил байна. Дийлэнх нь боловсролын зээлийн сантай холбоотой, он удаан жил шийдвэрлэгдээгүй асуудал байна. Хэдэн жилийн өмнө аудитын газраас энэ салбарт “зөрчилгүй” гэсэн дүгнэлт өгсөн бол одоо “хязгаарлалтай” гэсэн дүгнэлт өгсөн байна.



The Asia Foundation



Боловсролын
Хамтын Ажиллагааны
Нийгэмлэг



7

Чанар, хүртээмжийн хомсдол нь боловсролын салбарт авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх гол шалтгаан нөхцөл болж байгаад дүгнэлт хийх, ялангуяа олон улсын, Кембрижийн хөтөлбөртэй, лаборатори гэх мэт “онцгой сургууль” байгуулснаар эцэг эхчүүдийн дунд өрсөлдөөн бий болох, сургуулийг ялгаварлаж зэрэглэх, авлига үүсэх зэрэг нөхцлийг бий болгож байгаад онцгойлон анхаарах, сургалтын чанар, хүртээмжийг тал бүрийн оролцоотойгоор сайжруулах.

Баримт:

“Бүх нийт боловсролын төлөө!” ТББ-ын судалгаагаар олон улсын, Кембрижийн хөтөлбөртэй, лаборатори гэх мэт “онцгой сургууль” байгуулснаар улсын 800 сургууль сайн болохгүй, нийт сургуулийг чанаржуулах биш, ганц хоёрхон сургуулийг онцгойлон чанаржуулах бодлого алдаатай, авлигыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна.

8

Салбар хариуцсан яам бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж гэх мэт асуудлыг шийдвэрлэхэд түлхүү анхаарч байгааг таслан зогсоож, энэ төрлийн үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлдэг болох.

Баримт:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/343 дугаар тушаалаар баталсан 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 391,0 тэрбум төгрөгийн өртөгтэй 281 төслийг, үүнээс яаманд 188,5 тэрбум төгрөгийн 82 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

9

Адилхан байршилд, ижил хүчин чадалтай сургууль, цэцэрлэгийн барилга барихад 50-60 хувийн зөрүүтэй төсөвт өртөг төлөвлөдөг, нэгэнт төлөвлөсөн өртгийг нэмж батлуулдаг зэрэг нөхцөл байдлыг судалж, дүн шинжилгээ хийх.

Баримт:

Чингэлтэй дүүргийн 50 болон 24 дүгээр сургуульд ижилхэн 450 хүүхдийн суудалтай сургуулийн өргөтгөл барихад 24 дүгээр сургуульд 4,3 тэрбум, 50 дугаар сургуульд 2 тэрбум төгрөг төсөвлөсөн.

Баянгол дүүргийн 19 дүгээр сургууль, “Сэтгэмж” цогцолбор сургууль, Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд баригдах сургууль, 62 дугаар сургууль, Баянзүрх дүүргийн “Шавь” цогцолбор сургууль, Хан-Уул дүүргийн сургуулийн барилгын төсөвт өртөг 3,2-6,5 тэрбум төгрөгөөр батлагдсан.

Баянзүрх дүүргийн сувиллын цэцэрлэг, яслийн 10 дугаар цогцолборын барилгын ажлын төсвийг 2018 онд 4,8 тэрбум төгрөгөөр батлагдсан байсныг Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 5,7 тэрбум төгрөг болгон 2019 оны төсөвт тусгасан.



The Asia Foundation



Боловсролын
Хамтын Ажиллагааны
Нийгэмлэг



10

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн ба төрийн өмчийн бус бүх шатны сургалтын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд тавих хяналт, хариуцлагын механизмыг бий болгох, хууль тогтоомжийн биелэлтийг бүрэн хангуулах.

Баримт:

Мэргэжлийн хяналтын байгууллагын шалгалтад хамрагдсан 18 сургууль Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 333 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулах үлгэрчилсэн журам”-ыг зөрчин, 450.0-500.0 мянган төгрөгийг сургалтын төлбөрт бэлнээр болон хувийн дансаар хураан авсан, мөн “бүжиг”, “шатар”, “IQ”, “хөгжим”-ийн клубтэй гэрээ байгуулж, урлагийн заалыг түрээслүүлэн, хүүхэд бүрээс 80.0-100.0 мянган төгрөгийн төлбөр авч сургалт явуулсан.

11

Багшийн ёс зүйн дүрмийг багш нарт нэг мөр ойлгож, мөрдөж хэвшүүлэх талаар үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, багш нарт дэмжлэг үзүүлэх.

Баримт:

“Азийн сан”-гийн “Боловсролын салбарын ил тод байдал, ёс зүй, авлигын асуудал” судалгаанд, цэцэрлэг, сургуулийн сурагчдын 1200 эцэг, эхийг хамруулж, “та багшид нь бэлэг сэлт, мөнгө өгсөн үү?” гэхэд 57 хувь нь өгсөн хэмээн хариулсан байна. Шалтгаан нь эцэг, эхчүүд өөрсдөө санаачлан өгсөн байдгийг багш, сургуулийн захирал нар эсэргүүцэлгүй авдаг байна. Энэхүү өгсөн бэлэг сэлт, мөнгөний үр дүнд хүүхдийнхээ дүнг ахиулж чадсан хэмээн эцэг, эхчүүдийн 70 хувь нь үзсэн.

Авлигатай тэмцэх газарт 2018 онд боловсролын салбартай холбоотой гэмт хэргийн шинжтэй бус, авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй 111 гомдол ирсэний 19 нь их, дээд сургуультай холбоотой, 42 нь ерөнхий боловсролын сургуультай холбоотой, 38 нь цэцэрлэгтэй холбоотой, 12 нь төрийн байгууллагын удирдлагатай холбоотой гомдол байна. Тухайлбал, албан тушаалтан нь анги бүрт арав арван ширхэг витамин, орифлеймийн бараа заруулахаар тулгаж өгдөг, энэ ажлаа дүүргийн Засаг даргын Тамгын газарт ажилладаг албан тушаалтантай хамтран хийдэг, эцэг эхийн зөвлөл нэрийн дор хавтгайруулан мөнгө хураадаг, өгч чадахгүй хүүхдийг дарамталдаг, бусад хүүхдийн өмнө загнаж, зүй бус харьцдаг.

12

Цэцэрлэг, сургуулийн сургалтын чанарыг ил тод журмаар тогтоож, үр дүнг нийтэд зарлах.

Баримт:

Улсын хэмжээнд сургууль, цэцэрлэгийн сургалтын чанар ямар түвшинд байгааг хэн тогтоох, тогтоосон эсэх нь тодорхой биш байна. “Бүх



The Asia Foundation



Боловсролын
Хамтын Ажиллагааны
Нийгэмлэг



нийт боловсролын төлөө!” ТББ чанарын шалгалтын дүнг авахаар Боловсролын үнэлгээний төвд албан бичгээр хандахад “нууц, бодлогын чиглэлээр ашиглана, та нарт өгөхгүй” гэсэн хариу хэлсэн.

13

Цэцэрлэгийн бүртгэл, их, дээд сургуулийн элсэлт, шилжилт, дүнгийн нэгтгэл, диплом олголт зэрэг үйл ажиллагаанд блокчэйн технологийг ашиглах боломжийг судлан, 2019-2020 оны хичээлийн жилд хэрэгжүүлж эхлэх. Боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэлгүй хандагчид зориулсан мэдээллийг нэмэгдүүлж, илүү нээлттэй болгох.

Баримт: *Хэлэлцүүлгийн өмнө Авлигатай тэмцэх газраас гурван цэцэрлэг дээр очиж нөхцөл байдлыг шалгаж үзэхэд нэг цэцэрлэгт гэхэд цахим бүртгэлээр шалгараагүй, ямар аргаар орсон нь тодорхойгүй 26 хүүхэд суралцаж байсан бөгөөд ямар арга замаар орсон нь тодорхойгүй. Нөгөө цэцэрлэгт нь 15 хүүхэд хууль бусаар элсэн орсон байсан.*

Сургуулийн элсэлтийн комиссын шийдвэрт сургуулийн захирлууд, төрийн өндөр албан тушаалтнууд оролцдог, тэр ч бүү хэл, улс төрийн сонгууль хүртэл нөлөөлдөг талаар судалгаанд оролцсон багш нар ярьсан.

“БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ АВЛИГА, ТҮҮНЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧИД

УЛААНБААТАР ХОТ.

2018.12.05